

Тайлан модуль (З-ДБ-32) Магадлан итгэмжлэл, сургуулиар

БҮЛЭГ: БАЙГУУЛЛАГА

ДЭД БҮЛЭГ-1.3: Магадлан итгэмжлэл

Тайлангийн нэр 1: МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГ ДСЭН ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН 20 .../20 ... ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН МЭДЭЭ

Товч нэр: Магадлан итгэмжлэлээр

Код: З-ДБ-32

Үндэслэл: Үндэсний статистикийн хорооны даргын “Маягт, түүнийг нөхөх зааврыг шинэчлэн батлахыг зөвшөөрөх тухай” 2020 оны 03 сарын 24-ны өдөр А/30 тоот тушаал, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Маягт, түүнийг нөхөх зааврыг шинэчлэн батлах тухай” 2020 оны 05 сарын 27-ны өдөр А/223 тоот тушаал

Зорилго: Магадлан итгэмжлэгдсэн дээд боловсролын сургалтын байгууллагын мэдээллийг сургууль бүрээр хөтөлбөр, суралцагч, ажилтны мэдээллийг харах

Тайлант хугацаа: Жил бүрийн 10 сарын 15-ны дотор

Хамрах хүрээ: Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл(БМИҮЗ) нь байгууллагын магадлан итгэмжлэлийн мэдээллийг ДБУМС-ын “Магадлан итгэмжлэл” модульд бүртгэж тайлан бодуулж баталгаажуулан Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (БАЭТЗТБ)-д ирүүлнэ.

Магадлан итгэмжлэл, сургуулиар

Магадлан итгэмжлэгдсэн дээд боловсролын сургалтын байгууллагын мэдээллийг сургууль бүрээр хөтөлбөр, суралцагч, ажилтны мэдээллээр харуулна. Үүнд: * (З-ДБ-32) Магадлан итгэмжлэл, сургуулиар

ОН, ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН СТАТИСТИК

ХИЧЭЭЛИЙН Н ЖИЛ	ТОВЧ НЭР	ТАЙЛАНГИ ЙН КОД	ТАЙЛАНГИ ЙН ДЭЛГЭ РЭНГҮЙ НЭР	МАЯГТЫН ТӨРӨЛ	EXCEL	PDF	ТАЙЛАНГИ ЙН ЗААВАР ТАТАХ
2019-2020 оны хичээлийн жил	Аймаг, нийслэл, өмчийн хэлбэр, ангилаар	З-ДБ-32	ДЭЭД БОЛ ОВСРОЛЫ Н СУРГАЛТ ЫН БАЙГУ УЛЛАГЫН 20... / 20... ОНЫ ХИЧЭ ЭЛИЙН ЖИЛИЙН МЭДЭЭ, аймаг, нийслэл, дүүргээр	Албан ёсны маягт	link	link	татах

Тайлан модуль Тайлангийн заавар

(3-ДБ-32) МАЯГТ НӨХӨХ ЗААВАР

А.Үндсэн мэдээлэл

<p>ДУГААР 1</p>	<p>БАГАНЫН НЭР Сургалтын байгууллага</p>	<p>ЗААВАР (багана А) -Дээд боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй сургалтын байгууллагын нэрийг бичнэ. МД (багана Б) - Мөрийн дэс дугаарыг дугаарлан бичнэ.</p>
<p>2</p>	<p>Магадлан итгэмжлэл гэдэг нь</p>	<p>чанарын урьдчилан тогтоосон шалгуур, үзүүлэлтүүдийг хангаж байгаа буюу давуулан биелүүлж буй боловсролын байгууллага эсвэл түүний тодорхой салбарын үйл ажиллагааг эрх бүхий хөндлөнгийн этгээд магадлан шалгаж, хүлээн зөвшөөрөх үйл ажиллагаа юм. Магадлан итгэмжлэх үйл ажиллагаа нь боловсролын байгууллагын магадлан итгэмжлэл, боловсролын зэрэг олгох сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэл, шинээр нээх сургалтын хөтөлбөрийн урьдчилсан магадлан итгэмжлэл гэсэн үндсэн 3 хэлбэрээр явагдана.</p>
<p>3</p>	<p>Байгууллагын магадлан итгэмжлэл нь</p>	<p>тухайн боловсролын байгууллага Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөс тогтоосон шалгуур, шаардлага /стандарт/-ыг хангаж буй эсэхэд эрх бүхий хөндлөнгийн этгээд хараат бус үнэлгээ хийж, чанарыг баталгаажуулж, дүгнэлт гаргах үйл ажиллагаа юм.</p>
<p>4</p>	<p>Хөтөлбөрийн магадлан итгэмжлэл нь</p>	<p>тухайн боловсролын зэрэг олгох сургалтын хөтөлбөр нь тогтоосон шалгуур, шаардлага /стандарт/-ыг хангаж буй эсэхэд эрх бүхий хөндлөнгийн этгээд хараат бус үнэлгээ хийж, чанарыг баталгаажуулж, дүгнэлт гаргах үйл ажиллагаа юм.</p>
<p>5</p>	<p>Урьдчилсан магадлан итгэмжлэл нь</p>	<p>тухайн боловсролын байгууллагын шинээр нээх сургалтын хөтөлбөр Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөс тогтоосон шалгуур, шаардлага /стандарт/-ыг хангаж буй эсэхэд эрх бүхий хөндлөнгийн этгээд хараат бус</p>

ДУГААР	БАГАНЫН НЭР	ЗААВАР үнэлгээ хийж, чанарыг баталгаажуулж, дүгнэлт гаргах үйл ажиллагаа юм.
6	Магадлан итгэмжлэгдсэн сургалтын байгууллагын ангилал	(багана 1:4) -Дээд боловсролын сургалтын байгууллага нь Боловсролын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу их сургууль, дээд сургууль, коллеж гэсэн ангилалтай байна гэж заасан бөгөөд магадлан итгэмжлэгдсэн сургуулийг ангилан “1” гэж бичнэ (Дээд боловсролын тухай хуулийн 4.1-р заалт).
7	Их сургууль	(багана 1) -Бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалт эрхлэхээс гадна судалгааны ажил зонхилсон лаборатори бүхий эрдэм шинжилгээ-сургалт-үйлдвэрлэлийн нэгдэл хэлбэртэй дээд боловсролын сургалтын байгууллага байх бөгөөд их сургууль нь магистр, докторын сургалт дагнан эрхэлж болно гэж заасан бөгөөд магадлан итгэмжлэгдсэн сургууль нь их сургууль бол “1” гэж бичнэ.
8	Дээд сургууль	(багана 2) -Шинжлэх ухааны тодорхой чиглэлээр судалгаа, шинжилгээний ажил явуулж бакалаврын сургалт эрхлэх эрх бүхий сургалт-эрдэм шинжилгээний байгууллага мөн. Дээд сургууль нь магадлан итгэмжлэгдсэн сургууль нь дээд сургууль бол“1” гэж бичнэ.
9	Коллеж	(багана 3) -Дипломын болон бакалаврын сургалт эрхэлдэг сургалтын буюу сургалт-үйлдвэрлэлийн байгууллага байна гэж заасан бөгөөд заасан бөгөөд магадлан итгэмжлэгдсэн сургууль нь коллеж бол “1” гэж бичнэ.
10	Технологийн коллеж	(багана 4) -Дээд боловсролын зэрэг олгодог онолын мэдлэг, ур чадвар, дадал бүхий үйлдвэрийн инженер, технологичдыг бэлтгэх технологийн коллеж байх бөгөөд магадлан итгэмжлэгдсэн сургууль нь технологийн коллеж бол “1” гэж бичнэ.
11	Магадлан итгэмжлэгдсэн мэдээлэл&l	